



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/206

Булган

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Бат-Өлзий /ГЮ75040215/-ийн Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 107 тоотод байршилтай 6308004177 нэгж талбар бүхий орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 395 м² газар, Л.Бумбат /ГЮ68122570/-ын Булган сум 4 дүгээр баг Усны 2 дугаар гудамж 207а тоотод байршилтай үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшиж буй 1464 м² газрыг кадастрын зураглалаар 1469 м² болгон өөрчилж газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 3 жилээр тус тус сунгасугай.

2. Иргэн Д.Бат-Өлзий, Л.Бумбат нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээ олгон газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны Б/114, сумын Засаг даргын 2003 оны 116 дугаар захирамжийн Д.Бат-Өлзий, Л.Бумбат нартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ